1. Хэлэлцсэн нь:

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан ТУЗ-ийн дарга Н.Буянхүү / Тайланг хавсаргав /

Хурлын дарга Н.Цоож компанийн 2018 оны тайлангаас асууж тодруулах зүйл байгаа эсэхийг хувьцаа эзэмшигчдээс лавлахад доор дурьдсан асуулт хариулт явагдлаа.

Асуулт: Б.Ганбаяр

Бараа гүйлгээний хэмжээ яагаад буураад байна вэ?

Хариулт: Н.Цоож

Барилга гэр ахуйн барааны тасгаа хувь хүнд түрээслүүлдэг болсоноос компанийн борлуулалтанд тооцогдохгүй болсон. Дан хүнсний тасгаар хийсэн борлуулалт л манай бараа гүйлгээ юм. Худалдан авагчид аль болох тав тухтай орчинтой, барааны өргөн сонголттой, замд ойрхон, 1-р давхарт байрлалтай газруудаар үйлчлүүлэх сонирхолтой болсон байна.

Асуулт: Х.Нарантуяа

Хүнсний барааныхаа нэр төрлийг нэмэгдүүлж, мах ногоо худалдаалбал яасан юм вэ ?

Хариулт: Н.Цоож

Хүнсний дэлгүүр 2 давхарт байрлалтай. Худалдан авагчдын урсгал тааруугаас авчирсан бараа хугацаа нь дуусч алдагдал гаргаад байгаагаас хүмүүсийн өдөр дутам хэрэглэдэг бараагаар л хангадаг юм. Мах ногоо хурдан муудах эрсдэлтэй, хадгалах зоорь, хөлдөөгчгүй болохоор авчирч борлуулах сонирхол муутай байдаг. Мөн хүнсний захынхан НӨАТ төлөгч биш болохоор үнээ зохицож зарж борлуулаад байдаг байх.

Асуулт: А.Батбаяр

Ашиглалтгүй хоосон өрөө тасалгаа байгаа юм биш үү?

Хариулт: Н.Цоож

ХҮТөв маань 1985 онд ахуй үйлчилгээний зориулалтаар баригдсан байрыг худалдан авсан. Голын өрөөнүүд дандаа агуулахын зориулалттай харанхуй өрөөнүүд байдаг. Иймээс хүн орохгүй байна.

Асуулт: Д.Мөнх-Очир

Нэгдүгээр давхарт байсан бөөний цэг гараад эзэнгүй байгаа юмуу, яаж ашиглах гэж байна?

Хариулт: Н.Цоож